


# ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ

## НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн байдлаар буюу **8-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 9 аймагт **611** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



### Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 611 тохиолдлын 91% /554/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 9% /56/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Орхон /4/, Өвөрхангай /3/, Өмнөговь /3/, Төв /18/, Ховд /1/, Хөвсгөл /2/) бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **131** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

## 8 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.02.15 – 2026.02.21)

2026 оны наймдугаар долоо хоногт 109 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 75.8 хувиар, 5 жилийн дунджаас 102 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.

### Угаарын хийн цочмог хордлогын тохиолдлын хөдлөл зүй




## ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд 1-8 дугаар долоо хоногт нийт 243 иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 насны иргэд хамгийн их хордлогод өртөж байна.

2026 оны **наймдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **22** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 37.1 хувиар буурсан бол сүүлийн 5 жилийн дунджаас 29.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (8-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	0	6	6
2	Эмийн хордлого	8	8	16
<b>Нийт</b>		<b>8</b>	<b>14</b>	<b>22</b>

Нийт 22 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 16 (73%) нь эмийн хордлого, 6 (27%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 14 (64%) тохиолдол, санаатай хордлого 8 (36%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.

-ооо-